

## УВС АЙМГИЙН БӨХМӨРӨН СУМЫН НУТАГ ДАХЬ “ХОТГОР” ХХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хотгорын нүүрсний уурхай нь 1963 онд анх байгуулагдсан. “Хотгор” ХХК 1996 оны 05-р сарын 15-нд байгуулагдсан. 2 682 000.0 мянган төгрөгийн дүрмийн сантай, 1 гишүүнтэй. Чулуун нүүрс олборлох, борлуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг юм.

Нүүрсний уурхайн “Хотгор” ХХК үйл ажиллагаа явуулж байгаа газар нутаг нь засаг захиргааны хувьд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 7-р багт харьяалагддаг ба нутаг дэвсгэрийн хувьд Увс аймгийн Бөхмөрөн сумын 2-р багт хамрагдана. 7-р багийн төв нь бага сургуультай, холбоо болон хүн эмнэлэг, худалдаа үйлчилгээний төвүүдтэй. 7-р багт 135 өрх, 560 гаруй хүн оршин суудаг. Уг баг 2011 оны 11-р сард Бөхмөрөн сумаас цахилгаан дамжуулах агаарын шугаманд холбогдсон.

Тус уурхай олборлосон нүүрсээ дотоодын зах зээлд буюу Баян-Өлгий аймгийн хэрэглэгчдийг 100 %, Ховд аймгийн хэрэглэгчдийн 10-15 %-ийг, Увс аймгийн ойр орчмын сумуудын хэрэглэгчдийг нүүрсээр ханган ажилладаг юм.

Ордын нөөцийг бүрэн ашиглах зорилгоор 2013 оны 12-р сараас эхлэн нунтаг нүүрсийг шигшиж ангилан ялгах чичиргээт тоног төхөөрөмж суурилуулан ажиллуулж байна. Энэхүү ялгах машинаар урьд онуудад уурхай дотор хуримтлагдсан болон ачилтаас үлдэж буй нунтаг нүүрсийг стандартын дагуу шигшиж, ангилан ялгаж ард иргэдийн хэрэгцээнд бэлтгэн нийлүүлж байна.

- 1. Тусгай зөвшөөрөл:** “Хотгор” ХХК нь MV-001441, MV-014442, MV-020853 тоот тусгай зөвшөөрлүүдийг тус тус эзэмшдэг юм. 1441А тоот тусгай зөвшөөрлийг 1999 оны 03-р сарын 15-ны өдөр, 14442А тоот тусгай зөвшөөрлийг анх 2008 оны 11-р сарын 24-ны өдөр, MV-020853 тоот тусгай зөвшөөрлийг 2017 оны 6-р сарын 28-ны өдөр тус тус олгосон байна.
- 2. Ордын байршил:** Тус орд газар нь Увс аймгийн Бөхмөрөн сумын 2-р багийн газарт нутагт оршдог болно. Бөхмөрөн сумаас 58 км, Баян-Өлгий аймгийн төвөөс 133 км, Увс аймгийн төвөөс 120 км. зайд оршдог
- 3. Дэд бүтэц:** Аймаг, сумын төв, бусад суурин газруудтай ердийн хөрсний замаар холбогдсон ба суурин газруудтай утсан харилцаатай. Цахилгаан хангамжийн хувьд Бөхмөрөн сумаас өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбогдсон.
- 4. Ордын геологийн судалгааны түүх, судлагдсан байдал:** Монгол улсын баруун-хойт захын хэсэг 19-р зууны 2-р хагасын сүүлээр судлагдаж эхэлсэн юм. Монгол улсын баруун хэсэгт анхны судалгаа хийсэн хүн бол Оросын судлаач Г.Н.Потанин байсан. 1879 онд тэр Коч-Агашаас Өрөг нуураар Улаангом хүртэл очиход уг ордын районыг баруунаас зүүн тийшээ дайрч өнгөрсөн байна. Г.Н.Потанин өөрийн ажилд зөндөө сонирхолтой физик-газар зүйн баримт цуглуулсан.

Тэр бас өөрийн явсан маршрутаар тааралдсан уулын чулуулагуудын литологийн талаар их бичсэн байна.

1903 онд Оросын нэрт судлаач Грумм-Гржимайло Г.В Хархираагийн массив болон Увс нуурын хотгорын районд очсон байна. Өөрийн “Баруун-Монгол ба Урианхайн нутаг” гэх тэмдэглэлдээ антропологи болон этнографийн түүх, физик газар зүйн байдлыг мэдээлсэн байдаг.

Баруун-хойт Монголын геологи судалгааны ажил албан ёсоор ЗХУ-ын Шинжлэх Ухааны Академийн иж бүрэн экспедицийн ажилтанууд И.П.Рачковский, З.А.Лебедская, П.П.Сизова, М.Ф.Нейбург, Н.А.Куликов, А.И.Педашенко нарын бүрэлдэхүүнтэй 1923 оноос эхэлсэн. Энэ геологуудаар нилээд хэмжээний газар нутагт геологи-маршрутын судалгаанууд, геологийн зураглалын ажлууд хийгдсэн. Геологууд И.П.Рачковский, З.А.Лебедская, П.П.Сизова нар тусдаа отрядад ажиллаж Увс нуурын хотгорын хойт талыг судалж, Ачит нуурын районд очиж, Бургастайн голын хөндийгээр Хархираагийн нурууны доод палеозойн разрезыг нарийвчлан судлав. И.П.Рачковский 1927 онд Монгол Алтайгаас Хар-ус нуураар дамжин Ачит нуурын хотгор хүртэл маршрутаар явсан юм. Энэ үед хотгорын зүүн-хойт хэсэгт Улиастайн голын баруун талд Нүүрст-Хотгорын чулуун нүүрсний ордыг илэрүүлсэн ба үүний дараа И.Е.Турицев нарийвчлан судалсан байна. Анхны талбайн геологийн судалгааг 1941-1942 онуудад И.Е.Турицевын удирдлагаар хийж районы геологи, техник ашигт малтмалын тойм зургийг 1:1000000 масштабтайгаар зохиож, нөөцийг 2 тэрбум тн. гэж үнэлсэн байдаг. Гэвч И.Е.Турицевын энэ тооцоо хэтрүүлэн тооцогдсон гэж бичжээ. Яагаад гэвэл үйлдвэрлэлийн шаардлага хангахааргүй давхаргуудыг тооцож оруулсан ба баран өнгөтэй элсэн занарын давхраануудыг нүүрсний давхаргаар андуурч тооцсон байна.

1952 онд К.Л.Волочковичийн удирдлагаар 1:1000000 масштабтай геологийн зураглалын ажлыг хийж өмнөх зохиогдсон судалгааг үндсэнд нь өөрчилж шинээр геологи, техник ашигт малтмалын зургийг зохиосон. 1962 онд М.Н.Савокины удирдлагаар 1.0 \* 0.6 км. талбайд нарийвчилсан хайгуул хийж 12.483 сая тн нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр үнэлсэн. 1982 онд 1:200000 масштабын зураглалын ажлыг хийж районы геологийн тогтоцыг нарийвчлан тогтоосон нь өнөөгийн судалгааны тулгуур материал болж байна. Хотгорын уурхайд 1990-1991 онуудад хийгдсэн хайгуулын цооногуудад холболт хийх, 2 хэсэг газарт зураглал зохиох ажлыг 1991 оны 06-р сард ГШ-ний Улаанбаатар нэгдлийн топо-маркшейдерийн ангиас гүйцэтгэсэн байна.

## **5. Геологийн тогтоц:**

Энэ районы геологийн тогтоц нь төрөл бүрийн загварын литологийн найрлагатай мөн янз бүрийн насны чулуулгууд байдаг. Районы ихэнх хэсэг нь палеозойн насны чулуулагтай. Кембрийн өмнөх насны үүсэл бага тархсан. Мезозойн хурдас маш бага тархалттай. Дөрөвдөгч үүсэл маш их тархсан.

Докембрийн үүсэл Байрам болон Түргэн нуурын нуруугийн энгэрээр өргөн нь 20 км орчим туузан хэлбэртэй баруун-хойшоо чиглэлтэй тархсан байгаа. Докембрийн чулуулгууд хүчтэй эвдэрсэн, метаморфизд хүчтэй автагдсан атирааг үүсгэнэ.

Докембрийн литологитой үүсэл нь ерөнхийдээ хлорит-серециттэй, слюдо-хлориттой ба кремнитэй занаруудаас, мраморжсон шохойн чулууны линзнуудээс, гнейсийн төрлийн

кварцитын давхарганцартай гнейсүүдээс тогтсон байгаа. Палеозойн насны хамгийн хуучин хурдас нь силурын хурдасууд юм.

Силур. Силурын насны хурдасууд нүүрст-хотгорын ордоос зүүн-хойшоо чиглэлд өргөн тархсан. Уг үүслүүд Цагаан-Шибетын нуруу, Байрам нурууны төв хэсэг, Түргэн нуруу болон Ачит-нуурын хотгорын хойт захын хэсэгт бүтнээр тархсан.

Силурын чулуулгууд болон докембрийн чулуулгууд хүчтэй контакттай метаморфизмд баригдаж хэт нунтаглагдаж хүчтэй эвдэрсэн. Силурын ба докембрийн завсараар өнцөгийн хэт үл нийцлэг харагдана.

Нүүрст-хотгорын ордын геологийн тогтоцт дөрөвдөгч хурдасаар хучигдсан пермо-карбоны чулуулгууд оролцоно.

Ордын пермо-карбоны хурдасын бүрэн зүсэлтийг анх 1941 онд И.Е.Турицев судалсан ба түүний дараа К.Л.Волочкович дахин судалсан. Тэр Ачит-нуурын хотгорын зүүн-хойт захын дээд палеозойн чулуулгуудын зүсэлтийг судалж дороосоо дээшээ доорх атираад хуваасан байна:

1. 70-80 метр зузаантай суурийн хөрзөнгийн давхаргадас
2. 350-400 метр зузаантай бялхмал-тунамал давхаргадас.
3. 500-600 м зузаантай нүүрс агуулсан давхаргадас.
4. 200-250м зузаантай элсжин-хөрзөнгийн давхаргадас.

К.Л.Волочковичийн тооцсноор пермо-карбоны чулуулгуудын нийт зузаан 1000-1200 м-ээс багагүй байна.

Дээр дурдсан давхаргадасын литологийн найрлага доорх хэлбэртэй байна.

1. Суурийн хөрзөнгийн давхаргадас том ширхэгтэй хайрган чулуу, тод улаан өнгөтэй бага зэрэг цементжсэн хөрзөн зэргээс бүрдэнэ. Хайрага үндсэндээ жижиг ширхэгтэй саарал-ногоон элсжингээс, цахиуржсан чулуулгаас, лейкократтай юногерциний боржингаас тогтоно.

2. Чулуулгын бялхмал-тунамал давхаргадас доор байрласан улаан, шар кварцын порфиртай, элсжинтэй, туфолаватай, полимиктай элсжинтэй давхагадастай адил байрласан.

3. Ашигтай нүүрс агуулагч давхаргадас бялхмал-тунамал давхаргадастай адилхан байрлалтай. Тэр элсжин-хөрзөнтэй давхагадасын нэг хэсэг болж харагдана.

4. Ашигтай давхаргадас том ширхэгтэй саарал-шар өнгөтэй полимикттой элсжин, нүүрс агуулагч ба шааварлаг занар, алевролит, чулуун нүүрсний давхаргаас тогтсон.

Элсжин-хөрзөнгийн давхаргадас ашигтай давхаргадаст шилжигддэгээрээ холбоотой. Тэр том ширхэгтэй элсжиний давхрааны гравелитэй, том ширхэгтэй хайраган хөрзөнгээс бүрдэнэ. Пермо-карбонтой зузаалагын разрезын тухай К.Л.Волочковын бичсэнээр И.Е.Турицевын энэ разрезын тухай бичсэнээс нэг их ялгаагүй. И.Е.Турицевын энэ разрезын тухай бичсэний нэг гол дутагдлал нь графикжлалт ба нүүрс агуулагч түвшингийн ялгагдлын үндэслэл муу байсан. И.Е.Турицев шаавартай хар занарын давхаргыг нүүрснийг давхарга болгон тооцсон нь сүүлийн мэдээгээр тодорхой болсон. Түүний тодорхойлсон нүүрс агуулагч түвшинүүдээс нүүрсний давхарганууд илрээгүй тэнд зөвхөн шаавартай хар занарын давхарганууд байсан. Ийм явдал 1961 онд 338-р ангийн ажилд анзаарагдаж К.Л.Волочковын тайланд бичигдсэн байдаг. Жишээ нь И.Е.Турицевын

тайланд нүүрсний давхраганы гадаргуугийн гарц болгон үзүүлсэн фото зургууд тухайн тайлангийн зохиогчийн газар дээр нь үзэхэд шавартай хар занарууд болж гарсан. Дээрхи байдалуудаас харахад К.Л.Волочковын бичсэнээр пермо-карбоны разрез хамаагүй зөв, үнэмчлэлтэй гэж бодож болно.

## 6. Нүүрсжилт:

Чулуун нүүрсний Нүүрст-Хотгорын ордыг анх 1941 онд И.Е.Турицев судалж эхэлсэн. Тэрээр ордын хэмжээнд 24-25 нүүрсний давхарга, 0,1 м - 5,0 м зузаантай үенцэрүүд байгааг тэмдэглэж байсан. Хотгорын ордод 1990-1991 онуудад хийж гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажлаар ордын геологийн тогтоц, хэлбэр хэмжээ бүрэн судлагдсан. Судалгаагаар уг орд нь нүүрсний 8 давхраастай болох нь тогтоогдсон бөгөөд түүний 7 давхраасад нөөцийн үнэлгээ өгсөн болно. Ер нь ордын хэмжээнд бие даасан нүүрсний давхраасаас гадна 0.1-1.8 м зузаантай нүүрсний нарийн үе, лэнзүүд нэлээн байдаг. Ордын хэмжээнд ажиглагдаж буй ерөнхий нэг зүй тогтол бол нүүрсний бүх давхраасууд, уналынхаа дагуу зузаан нь нимгэрч, уналын өнцөг багасаж, ордын урд жигүүрт газрын гадаргад гарахгүй шувтарч алга болно.

## 7. Нүүрсний нөөц:

1990-1991 онуудад хийгдсэн геолог-хайгуулын ажлаар Нүүрст хотгорын ордын хэмжээнд нийт 166.6 сая тн. нөөц тогтоосноос балансын нөөц А+В+С<sub>1</sub>-ээр 143.3 сая тн. нөөцийг улсын нөөцөд бүртгүүлсэн байна. 1441А тоот тусгай зөвшөөрөлтэй талбайд хамрагдах нүүрсний нөөцийг анх 1963 онд 12.483 сая. тн-оор тогтоосон байдаг юм.

7.1 2013 оны 12-р сарын 24-ны өдрийн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ХХ-24-03 тоот тэмдэглэлд Нүүрст хотгорын 1441А талбайд хамаарах Хотгор хэсгийн нүүрсний үлдэгдэл бодитой /В/ нөөцийг **2.898** сая. тн-оор баталсан юм.

7.2 14442А тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нүүрсний нөөцийн тооцоог 2011 оны 05-р сарын 20-ны өдрийн ХХ-09 тоот Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн тэмдэглэлээр **8.410** сая тн-оор баталсан.

7.3 020853А тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах нүүрсний нөөцийн тооцоог 2017 оны 02-р сарын 23-ны өдрийн ХХ-02-06 тоот Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээр **10.435** сая тн-оор баталсан.

## 8. Гидрогеологийн судалгаа:

Нарийвчилсан хайгуулын ажлын явцад ордын төв хэсэгт хайгуулын 12-р шугам дээр 94 м гүнтэй 84-р цооногт гидрогеологийн шавхалт туршилтын ажлыг техник гидрогеологич В.Нямаа хийж гүйцэтгэсэн. Энэ цооногийг 110 мм-ийн голчтой өрөмдөж шүүрийг 34.0 – 52.0 м суулгаж рельефтийн аргаар шавхалтыг хийсэн. Үлээлгийн янданг 54 м, хэмжилтийн янданг 59 м-т суулгаж НВ -10 маркийн компрессороор шавхалтыг явуулж шавхалтын үед усны ундарга, түвшний бууралт, сэргэлтийг зохих шаардлага, зааврын дагуу хийж гүйцэтгэсэн.

Ордын хэмжээнд газар доорх усны түвшин нь 3.0 – 66.0 м-т байна. Гэхдээ ордын зүүн жигүүртээ 20.0 – 66.0 м –т байхад баруун хэсэгт 3.0 – 11 м-т байгаа нь ордын баруун хойд хэсэгт орших Байрам хөвийн булаг баруун урагшаа чиглэлтэй урсдагтай холбоотой байж болно. Шавхалтын материалаас үзэхэд цооногийн ундарга 0.5 сек/л, түвшний бууралт 7.2 м, түвшний сэргэлтийн хугацаа 12 цаг буюу 720 минут, хувийн

ундарга 0.06 л/сек байна. Ордын гидрогеологийн нөхцөл нүүрсний бусад ордуудтай харьцуулахад, мөн ашиглалтын өнөөгийн түвшинд онцгой хүндрэл үзүүлээгүй зэргээс үзэхэд ашиглалт явуулахад нэлээн тааламжтай.

Энэ ордын районд тархалтаар хоёр үндсэн бүлэгт хувааж болно: гадаргуугийн ус ба газар доорх ус.

Гадаргуугийн усанд нуур болон голын ус орох ба уг районд өргөн тархалттай. Түүнээс гадна өндөр уулсын хэсэгт сүүлийн үеийн мөсжилт /Түргэн-нуурын нуруу/ байдаг ба үүнийг бүлгийн хэсэгт хамааруулна: Далайн хурдасын ус, цасан болон мөсөн голын байлаар байгаа цасны шугамаас дээшээ байрласан ус.

Газрын доорх ус ерөнхийдээ:

А. хагарлын ба давхарга-хагарлын,

Б. дөрөвдөгч хурдасын ус.

Хагарлын ба давхарга-хагарлын ус районы хүчтэй хэсэгчилэгдсэн өндөр уулсын бүст тархсан. Дөрөвдөгч хурдасын ус зөвхөн нуурын хотгорын хэмжээнд ба сэвсгэр хурдасын том жижиг зузаантай, зузаалагтай уул хоорондын хотгорд тархсан.

Доор Нүүрст-Хотгорын ордын хэмжээнд тархалттай усны үндсэн бүлгүүдийн товч шинж чанарыг хүргэв.

#### **А. Гадаргуугийн ус.**

Гадаргуугийн ус ерөнхийдээ нуур болон голын уснаас бүрдэнэ. Голууд районы өндөр уулын хэсгээс эх авна. Тэд мөсөн голын хайлж урссан ус, цас борооны хэлбэрээр унасан атмосферийн тундас зэргээс тэжээл авна. Голын усны ихсэлт хавар, зуны улиралд байдаг энэ нь мөсөн гол болон цас хайлж хур тундас их байдагтай хамаатай.

Энэ үед усны урсгал дээд хэмжээнд хүрнэ. Районы ихэнх голын урсгал уулын хавцалаар урссан хэсэгт гадаргуугийн урсгалтай. Голын урсгал тал газарт гарсан хэсэгт гадаргуугийн урсгал харагдахгүй дараагийн гол эсвэл нуур хүртэл бул чулуутай хайраган үүслийн доор урсдаг.

Тийм голоор Нүүрст-Хотгорын ордын хэсэгт урсдаг Улиастайн гол ба Байран хавийн булгийг хэлж болно.

Өвлийн улиралд энэ хавийн ихэнх гол бүтнээр хөлддөг. Тийм голын хөндий 3-4 метр хүртэл зузаантай хөлдсөн байдаг. Энэ хэсгийн бүх голын ус тунгалаг, ундны чанараар маш сайн нутгийн ард түмний усны хэрэгцээг хангаж байгаа. Энэ районы нутаг дэвсгэрт хамгийн ойрхон нуур бол Ачит-нуур ба түүнээс Усан хоолойн гол гарч Ховд голд цутгадаг. Ачит нуурын ус гадаргуугаас болон газар доороос хангамж авна.

#### **Б. Газар доорх ус.**

Энэ районы хэсгийн газар доорх ус дээр дурдагдсанаар гурван бүлэгт хуваагдана: хагарлын, хагарал-давхаргын, давхаргын.

Ордын талбайн хэсэгт түүн дотор баруун ба зүүн талын хэсэгт уулархаг өндөр гадаргуутай учир усны эхний хоёр бүлэг их тархалттай. Давхаргын ус сэвсгэр хурдасаар бүтсэн хотгор, хөндий ба янз бүрийн нам гадаргуу зэрэг маш бага талбайд тархалттай.

Хагарлын ба хагарал-давхаргын ус тунамал болон оргилолт чулуулагуудын дунд тархалттай. Уг чулуулагуудын усны ханамж гадаргуугийн хэлбэр, гипсометрийн

харьцангуй өндөрлөг, тухайн газрын геологийн тогтоц, чулуулагын петрографийн найрлага зэргээс хамаарна

Чулуун нүүрсний Нүүрст-Хотгорын орд Ачит-нуурын зүүн хойт хэсэгт Байрам, Түргэн-нуруунуудын өмнөд энгэрийн хормойд байрласан. Энэ орд пермо-карбоны чулуулагуудаас бүрдсэн. Пермо-карбоны үүсэл литологийн харьцаагаар ан цав ихтэй элсэн-шааварын төрөлд хамаарна. Дээр бичигдсэн гидрогеологийн ерөнхий байдлаас шалтгаалан ордын гидрогеологийн нөхцөлийг тодорхойлох болно.

Ордын ус гадаргуугийн ба газар доорх гэж хоёр төрөлд хуваагдана.

Гадаргуугийн усаар ордын хэсэгт урсдаг Улиастайн гол ба Байрам хавийн булаг зэрэг хоёр голын гадаргуугийн урсгал багтана. Уг голууд Байрам болон Түргэн-нуурын уулын нуруугийн цас, мөсийн хайлсан уснаас эх авна.

Энэ хоёр гол өндөр уулархаг, хүчтэй хэрчигдсэн хэсэгт гадаргуугийн урсгалтай байх ба тэгш тал газарт урсгал нь алга болно. Цаашдын урсгал бул чулуу-хайрган үүсэллийн доогуур үргэлжилнэ.

Улиастайн гол талбайгаас зүүн-урагшаа 5 км-т урсах ба Байрам-хавийн-булаг гол 1200 м зайтай хойт талаар урсана. Хайгуулын талбайн хэмжээнд энэ голууд байнгын гадаргуугийн урсгалтай ба цаашаа гүн рүүгээ ширгэнэ.

Талбайн гадаргуугийн өндөрлөг хамгийн ойрхон Байрам-хавийн-булаг голоос 30-50 метр өндөрийн хэмжээнд байгаа. Голын ундарга тогтмол биш, улирлын байдлаас хамаарна. Хавар, зуны улиралд цас-мөс хүчтэй хайлж голын ундарга дээд хэмжээнд хүрнэ.

Байрам хавийн булаг голын ундарга 8-р сард хэмжихэд 1000-1200 куб.м<sup>3</sup>/цаг хэмжээтэй байсан. Өвөл голын ус бүтнээр хөлдөж гадаргуугийн урсгалгүй болно.

## **9. Уул геологийн нөхцөл:**

Нүүрст хотгорын ордын уул геологийн нөхцлийг 1960 онд Сависоны удирдлагаар ордын зүүн хойд хэсэгт хийгдсэн нарийвчилсан хайгуулын ажлын үр дүнг үндэслэн тогтоож, ордыг 1963 оноос эхлэн ил аргаар ашигласан.

Ил уурхайн хажуу хананы налуугийн өнцгийг 20-35<sup>0</sup>, уурхайн гаднах овоолгын өндөр 22.0 м, налуу өнцөг 35<sup>0</sup> байгаа. Ил уурхайн гүн бага, овоолгын өндөр харьцангуй бага, өнөөгийн нөхцөлд ашиглалтын мөргөцөг ба ил уурхайн хажуу хананд гулсалт нуралт үүсч, ашиглалтад хүндрэл гараагүй байна. Хотгорын нүүрсний ордын нүүрсний давхаргын уналын өнцөг бага тул одоо ил аргаар олборлож байгаа.

Ил уурхайн мөргөцгийн тогтворжилтонд дараах хүчин зүйлүүд нөлөөлнө. Үүнд:

1. Чулуулгийн геотектоникийн шинж төлөв уурхайн хана, мөргөцөг буй болох үед чулуулгийн барьцалдалт, түүний холбоос, бутрамтгай байдлаас хамаарч өөрчлөлтөнд орно. Тухайн хайгуулын талбайн хөрс хуулалтын хэсгийн чулуулаг нь сул цементлэгдсэн, нягт хатуу элсэн чулуу, аргиллит голлон тогтсон.
2. Нэгэн төрлийн чулуулаг их хэмжээгээр ил уурхайн хананд байгаа эсэх. Өрөмдлөгийн судалгаа, геологийн зүсэлтээс харахад элсэн чулуу, аргиллитын нэгэн төрлийн үе тохиолдоно.
3. Ашигт малтмалын ерөнхий байрлал, уналын хэмжээ, чиглэл нөлөөлөх байдал. Тусгай зөвшөөрлийн талбайн чулуулгийн тогтоц үндсэндээ нүүрсний давхраасын ерөнхий унал 10<sup>0</sup> бөгөөд тектоник хагарал байхгүй тул олборлолтонд хүндрэл гарахгүй.

## 10. Нүүрсний шинж чанар:

Ордын нүүрс нь энгийн нүдээр харахад гялгар, хагас гялгар бүдэгдүү гялгатай, голдуу нэг төрлийн бат бөх шинжтэй, хар өнгийн чулуун нүүрс юм. Өгөршлийн бүсэд хар хүрэн өнгөтэй, бүдэг гялгатай, нунтаг бутрамтгай шинж чанартай болно.

Нүүрст хотгорын ордын нүүрсний давхраасуудад талбай болон гүний хувьд чанарын өөрчлөлтийн тодорхой зүй тогтол тогтоогдоогүй бөгөөд нүүрсний давхраасууд нь хоорондоо чанарын онцгой ялгаагүй болох нь геологи-хайгуулын үед хийсэн лабораторын шинжилгээний үр дүнгээс харагдсан.

Тус уурхайн нүүрсний чанарын үзүүлэлтийг Ашигт малтмалын газрын шинжилгээ туршилтын лабораторид шинжлүүлдэг юм. Нүүрсний физикийн шинж чанар нь чулуун нүүрсний төрөлд хамаарна.

## 11. Уурхайн ашиглалт эхэлснээс хойшхи үйл ажиллагааны түүх:

Хотгорын нүүрсний орд нь Монгол орны хамгийн баруун хязгаарт буй Байрамын нурууны өвөрт орших нүүрсний орд газар.

Хотгорын нүүрсний уурхай МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөлийн 1963 оны 3-р сарын 30-ны өдрийн 74/180-р хурлын тогтоолоор анх байгуулагдсан түүхтэй. Уурхай нь Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг дэвсгэрт оршдог.

Засаг захиргааны хувьд Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 7-р багт харьяалагддаг юм. Нүүрсний орд нь Өлгий хотоос 133 км., Бөхмөрөн сумаас 58 км-ийн зайнд оршдог. Анхны төслөөр жилд 20-30 мянган тонн нүүрс олборлох хүчин чадалтайгаар байгуулагдсан.

### Нүүрсний чанарын үзүүлэлт стандартаар:

Үзүүлэлтүүд	Үнслэг /%/ дээшгүй А аж.	Чийглэг /%/ дээшгүй W	Ерөнхий хүхэр /%/ дээшгүй S ер.	Дэгдэмхий бодис /%/ доошгүй, V r	Илчлэг /мж/ кг., багагүй Q
Чулуун нүүрс	30	5	0,4	27,0	17,1

“Хотгор” ХК нь 2001 оны 07-р сард Төрийн Өмчийн Хорооны дуудлагын худалдаагаар хувьчлагдсан юм. Тус компанийн техникийн хүчин чадал жилд 200 мян. тонн нүүрс олборлох бололцоотой. Сүүлийн жилүүдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалан жилд 95 – 100 мян. тонн нүүрс олборлон борлуулж байна. Хотгор ХХК нь ил уурхайн аргаар нүүрс олборлох техник төхөөрөмжөөр бүрэн хангагдсан. Тухайлбал: КОМАЦУ маркийн экскаватор 2 нэгж, САТ маркийн экскаватор 2 нэгж, Хуйндай 520, Дусан 520 маркийн экскаватор 2 нэгж, 150 квт дизелийн станц 2 нэгж, Авто ачигч 3 нэгж, HOWO, БЕНЗ маркийн хүнд даацын өөрөө буулгагч

автомашин 10 нэгж, хийн компрессор 2 нэгж, өрөм 2 нэгж, нунтаг нүүрсийг шигшиж ангилан ялгах тоног төхөөрөмж 1 ком, зам талбай услах автомашин, техникийн өвлийн дулаан гараж, засвар үйлчилгээний цех, 10 кВ-ын дэд станц, шатахуун түгээх станц тус тус ажиллаж байна.

Тус уурхай үйл ажиллагаа явуулж байгаа Өлгий сумын 7-р баг нь 2011 онд өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугаманд холбогдсон юм. 2011 оны 08-р сард 100 тоннын электрон автопүүг шинээр худалдан авч суурилуулан, ашиглалтанд оруулсан байдаг.

Сүүлийн жилүүдэд хөрс хуулалтын ажлыг 3, 4, 5, 6,-р саруудад хийж дуусган, нүүрс худалдан авагч хэрэглэгч нарт өглөөний 08 цагаас эхлэн үйлчилж, оройн 17 цагаас өмнө ирсэн тээврийн хэрэгсэлд өдөртөө багтаан нүүрс ачсанаар хонох, өнжих чирэгдэл арилсан нь тэдний талархлыг зүй ёсоор хүлээж байна.

2001 оноос эхлэн техникийн нөхөн сэргээлт хийх замаар зам гарцыг техникийн шаардлага хангахаар сайжруулсан. Олборлолтонд өртсөн, нүүрсний нөөц дууссан хоосон талбайг хөрс хуулалтаас гарсан хөрс, чулуулагаар дүүргэлт хийж, булж тэгшлэх аргаар нөхөн сэргээлтийн ажил уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийгдэж байна.

2009 оноос эхлэн техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд биологийн нөхөн сэргээлт хийж байна. Биологийн нөхөн сэргээлтийн гол зорилго нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг үржил шимт хөрсөөр хучиж ургамалжуулахад оршино.

54 үндсэн ажилчинтай ба түр гэрээгээр нүүрс ялгах ажилд 4-6 хүн авч ажиллуулж байна. Уурхайн үндсэн ажилчид нь 4-33 жил ажилласан ба ихэнх ажилчид нь хоёр, гурван үе дамжсан хүмүүс бөгөөд үйлдвэрийн үндсэн ажилчдын 25 % нь хос мэргэжилтэй, нэг нь нөгөөгөө орлон ажиллаж чадах мэргэжлийн дадлагатай хүмүүс юм.

Манай хамт олноос хөдөлмөрийн олон сайчууд төрөн гарсан юм. Жишээлбэл: Гавьяат уурхайчин 1 хүн, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 5 хүн, алтан гадас одонгоор 14 хүн, хөдөлмөрийн хүндэт медалиар 33 хүн, тэргүүний уурхайчин цол тэмдгээр 54 хүн, мөн 20 хүн аймгийн хөдөлмөрийн, 57 хүн үйлдвэрийн мэргэжлийн аварга цолоор тус тус шагнагдсан байна.т “Хотгор” ХХК нь жил бүрийн төлөвлөгөөт зорилтуудаа тоо, чанар, үр ашгийн өндөр үзүүлэлтээр биелүүлж, өвлийн их ачааллыг амжилттай давж, Баян-Өлгий аймгийн хэрэглэгчдийг 100 %, Ховд аймгийн хэрэглэгчдийн 10-15 хувийг, Увс аймгийн ойрын сумуудын хэрэглэгчдийг нүүрсээр тасралтгүй хангаж, тэдний талархлыг зүй ёсоор хүлээж ажилласаар байна.

## **Борлуулалтын зах зээл, хэмжээ, үндсэн хэрэглэгч:**

Тус компани олборлосон нүүрсээ дотоодын зах зээлд борлуулдаг юм. Сүүлийн жилүүдэд дундажаар 95 -100 мян. тонн нүүрс олборлон борлуулж байна. Үндсэн хэрэглэгч нь Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудын аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэрэглэгч нар болох айл, өрхүүд болно.

## **12. Байгаль орчныг хамгаалах талаар:**

Төрийн захиргааны байгууллагаар батлуулсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-ний тайланд тусгасан зүйл заалтын дагуу “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г боловсруулж, БОАЖЯ-аар батлуулан, мөрдөн ажиллаж байна.

**MV-001441 тоот тусгай зөвшөөрөл нь** 39.2 га талбайтай. Уг талбайг 1963 оноос эхлэн ил уурхайгаар ашиглаж ирсэн. 2023 оны 10-р сарын 01-ний байдлаар нийт 25.34 га талбай олборлолтонд өртсөн байдаг. Олборлолтонд өртсөн нийт 25.34 га талбайн 13.65 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна. Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн 13.65 га талбайн 7.62 га-д биологийн нөхөн сэргээлт хийж орон нутгийн мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгсөн юм. Тус талбайд 2023 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулсан болно.

**MV-014442 тоот тусгай зөвшөөрөл нь** 77.8 га талбайтай байсан. Уг талбайг 2012 оноос эхлэн ашиглаж байна. Усны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтыг зөрчсөн шалтгааны улмаас 14442А тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн 26.52 га талбайг 2014 оны 09-р сард хэсэгчлэн буцаан өгч, 51.25 га талбайг MV-014442 тоот тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглэсэн юм. 2023 оны 10-р сарын 01-ний байдлаар нийт 8.42 га талбай олборлолтонд өртсөн байна. 2023 онд 0.33 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн болно. Олборлолтод өртсөн нийт 8.42 га талбайн 1.83 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.

**MV-020853 тоот тусгай зөвшөөрөл нь** 55.62 га талбайтай. Уг талбайг 2019 оны 7-р сараас эхлэн ил уурхайгаар ашигласан. 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар бүгд 11.52 га талбай олборлолтонд өртсөн байдаг. Олборлолтонд өртсөн нийт 11.52 га талбайн 7.26 га газарт техникийн нөхөн сэргээлт хийгдсэн байна. Тус талбайд 2023 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй болно.

## **Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл:**

Газар эдэлбэрийн байдал. “Хотгор” ХХК нь MV-001441, MV-014442, MV-020853 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг тус тус эзэмшдэг юм.

MV-001441 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ – 39.2 га

MV-014442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ – 51.25 га

MV-020853 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ – 55.62 га болно.

**MV-001441 талбайн хэмжээ**

№	Үзүүлэлтүүд	2023 оны 10-р сарын 01-ний байдлаар талбайн хэмжээ /га/
1	Нийт талбай	39.2
2	Олборлолтонд өртсөн талбай	25.34
3	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	13.65
4	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	7.62
5	Үржил шимтэй хөрсний овоолго	0.085
6	Нунтаг нүүрсний овоолго	1.6
7	Уурхайн автозам	2.2
8	Засварын газар	0.1

Хөрс хуулалтаас гарч буй хөрс шороо, чулуулагаар эвдрэлд орсон уурхайн хоосон орон зайд дүүргэлт хийн, техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж байна.

**MV-014442 талбайн хэмжээ**

ä/ä	Үзүүлэлтүүд	2023 оны 10-р сарын 01-ний байдлаар талбайн хэмжээ. /га/
1	Нийт талбай	51.25
2	Олборлолтонд өртсөн талбай	8.42
3	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	1.83
4	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	-
5	Үржил шимтэй хөрсний овоолго	0.35
6	Нунтаг нүүрсний овоолго	0.025
7	Уурхайн автозам	0.2
8	Засварын газар	0.1

Хөрс хуулалтаас гарч буй хөрс шороо, чулуулагаар эвдрэлд орсон уурхайн хоосон орон зайд дүүргэлт хийн, техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэж байна.

### MV-020853 талбайн хэмжээ

ä/ä	Үзүүлэлтүүд	2023 оны 10-р сарын 01-ний байдлаар талбайн хэмжээ /га/
1	Нийт талбай	55.62
2	Олборлолтонд өртсөн талбай	11.52
3	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	7.26
4	Биологийн нөхөн сэргээлт хийсэн талбай	-
5	Үржил шимтэй хөрсний овоолго	0.15
6	Нунтаг нүүрсний овоолго	-
7	Уурхайн автозам	0.1
8	Засварын газар	-

Тайлбар: 2023 онд MV-020853 талбайд ашиглалт явуулаагүй болно.

**Агаар, хөрс, ургамал, усан орчинд үзүүлэх нөлөөлөл:** Хөрс хуулах, нүүрс олборлох явцад тэнд ажилласан машин механизмуудын түлшний шаталтаас гарах хорт хий /азотын давхар исэл, хүхэрлэг хий, хар тугалга/, утаа болон цаг агаарын хуурайшилттай үед тэдгээрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн хөрснөөс тоос босох, дуу чимээ ихсэх зэргээр агаарын чанарт хими болон физикийн тодорхой нөлөөлөл үзүүлэх магадлалтай. Тоос босохоос урьдчилан сэргийлж, машин, механизм явах автозамыг байнга усалж, чийглэж байгаа. Уурхай доторх хөрс, нүүрсний тээвэрлэлтийг “HOWO” “НОРД БЕНЗ” маркийн автомашинаар гүйцэтгэж байна. Хөрс шороо салхинд хийсч туугдан хөрсний эвдрэл идэвхжинэ. Иймд хөрс хуулалт, нүүрс олборлолт ба тээвэрлэлтийн явцад зам талбайг байнга чийглэж ажиллаж байна.

**Ургамлын бүрхэвч** нь эх газрын хөрсний тогтворжилтийг хэвийн байлгах гол хүчин зүйл билээ. Иймд нүүрс олборлож буй талбайн хөрс хуулалт, карьер, овоолгын шороонд энэ хэсэг газрын ургамлын нөмрөг алга болох учир байгаль орчны харилцан зохилдсон тэнцвэрт байдалд зохисгүй нөлөөлж, ургамалжилт нь унаган төрхөө алдаж болзошгүй.

Уурхайн эзэмшлийн хүрээн дэх ухагдсан газар, хөрс хуулалт, гадаад овоолго ба хамгаалалтын далангаас гадна автомашин, хүнд механизмын хөдөлгөөн, зам харгуй, тосгоны суурины амьдрал, хүний нөлөөнд өвс ногоо, ургамал сийрэгжиж халцрах, төрөл зүйл цөөрөх зэргээр үлэмж талхлагдах болно.

**Амьтны аймаг:** Уурхайн эдэлбэр газрын талбайд хамрагдсан газарт байршиж байсан жижиг мэрэгч мэтийн цөөн бодгалиуд нүх, үлийнхээ хамт устаж үгүйрнэ. Хэлмэгдсэн эдгээр зүйл амьтад уурхайн орчин тойрны нутагт элбэг тархалттай

байдаг тул эдгээр амьтдын амьдрах орчинд онцгой нөлөө, сөрөг үр дагавар үзүүлэхээргүй байна.

Эдэлбэр газрын ойр хавийн нутгийн зарим ан амьтан уурхайн болон хүний үйл ажиллагааны шууд ба дам нөлөөнөөс болж байршил нутаг нь өөрчлөгдөн ховордож цөөрөх, эзгүйрэх үзэгдэл гарч болзошгүй.

#### **Дэд бүтэц, зам тээвэрт нөлөөлөх нь:**

Уул уурхайн олборлолтын явцад эвдэгдэж устсан үржил шимт хөрс дахин сэргэж бий болоход асар урт хугацаа шаардагддаг учир олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж, тээврийн хэрэгслийн жолооч нарт зөвхөн замын 2 талаар шуудуу татсан замаар явахыг байнга сануулан хэлж өгч, олон салаа зам гаргахгүй байхыг сануулсан анхааруулгын самбар босгосон.

#### **Хатуу хог хаягдлын талаархи мэдээлэл:**

Уурхайн тосгоны хэмжээнд үүсэх хатуу хог хаягдлыг ахуйн болон машин техникээс сольсон сэлбэг хэрэгслийн гаралтай хаягдал гарч байна.

Уурхайн тосгоны ахуйн гаралтай хатуу хог хаягдлын эх үүсвэрт ажиллагсдын оршин суух байр, гал зуух, ажлын байр, угаалгын өрөө гэсэн үндсэн объектуудаас гарах хог хаягдлууд орж байна. Нүүрст хотгорын уурхайгаас эхний 9 сарын байдлаар 15 м<sup>3</sup> хатуу хог хаягдал гарсан байна. Гарсан хатуу хог хаягдлыг Хотгор тосгоны хогийн цэгт зайлуулсан. Техникийн сольсон эд анги, төмрийн хаягдлыг тусгай талбайд хураасан.

#### **Уурхайн үйл ажиллагаанаас болж байгаль орчинд учруулах бодит хор нөлөөллийн тухай болон болзошгүй аюулын тухай тэмдэглэл.**

Увс аймгийн Бөхмөрөн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Нүүрст хотгорын ордыг ашиглах төслийн аюул ослын үнэлгээг “Гамшгаас хамгаалах тухай” хуулийн 27-р зүйл болон Байгаль орчны сайдын тушаалаар батлагдсан “Төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл болон байгаль орчны өнөөгийн суурь нөхцөл байдал, цаашдын өөрчлөлтийн хандлагаас төслийн хэрэгжилтэд нөлөөлөх болзошгүй аюул, ослын нөхцөл байдалд логик дүн шинжилгээ хийх байдлаар тодорхойлохыг зорилго болгосон байдаг.

Осол, эрсдэлийн дүн шинжилгээнд төслийн зарим үйл ажиллагаанаас болзошгүй техникийн холбогдолтой осол болон аюулт үзэгдлийн үед үүсэх онц уршигтай сөрөг нөлөөллийн өөрчлөлт, гамшгийн хор уршгаар төслийн цаашдын хэрэгжилтэд ноцтойгоор нөлөөлж болох эрсдэлийг тодорхой хүрээнд авч үзсэн болно.

## **Үйл ажиллагааны явцад гарч болзошгүй осол болон аюулт үзэгдлийн эрсдэл.**

Хотгор ХХК-ийн нүүрсний ил уурхайн “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ”-г 2021 онд “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төв”-өөр шинэчлэн гүйцэтгүүлэн батлуулсан.

- Гал, ус, аянга цахилгаан, газар хөдлөлт зэрэг гэнэтийн болзошгүй аюул ослын эрсдэлийг тооцож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь аливаа үйлдвэрийн үйл ажиллагааны нэг чухал хэсэг байдаг.
- Аадар бороотой зуны улирал болон цас хайлах үеийн шар усны үерээс болгоомжлох зорилгоор 2023 онд ашиглалтын талбайн гадна талаар татсан үерийн хамгаалалтын шуудууг сэргээн цэвэрлэсэн болно.
- Монгол орны байгалийн гамшгийн эрсдэлийн болон эмзэг байдлын үнэлгээнээс үзэхэд хээрийн түймэр 3-5 жилд 1 удаа гарах магадлалтай. Иймээс гал түймрээс урьдчилан сэргийлэх, галын болзошгүй аюулд өртөхөөс болгоомжлох хэрэгтэй. Гал унтраах анхан шатны зэвсэглэмжийг бүрдүүлэн ашиглахад бэлэн байлгах /MFZ/ ABC4A маркийн гал унтраагуур, хүрз, хувин, сүх, эсгий, резинэн цохиур, төмөр савар гэх мэт/ мөн татсан тамхи, шүдэнзний галыг гүйцэд унтрааж хэвших, үнс нурмийг тусгайлан бэлтгэсэн таглаатай савд хийх
- Галын болзошгүй аюул, ослын үед авах арга хэмжээний бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг “Галын аюулгүй байдлын тухай” хуулийн шаардлагад нийцүүлж хийвэл зохино
- Цахилгаан тоног төхөөрөмжийг зураг төслийн дагуу холбож угсрах, цахилгааны ашиглалт, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан байх, гэрэлтүүлэг, цахилгааны шугамууд богино холбоо үүсэх, шалбарч гэмтсэн хэсгийг тухай бүр илрүүлж аюулгүй ажиллагааг хангаж ажилласан болно.
- Машин механизмын мотор болон бусад эд ангиас шатах тослох материал, шүүрэлт гоожихгүй байх. Хяналт тавьж ажиллав.

Уурхайд ажиллагсдын эрүүл мэнд, орчны эрүүл ахуй, байгаль орчныг хамгаалах явдал чухал юм. Ажиллагсдын эрүүл мэнд, ажлын байр, орчны эрүүл ахуйг хамгаалах нь уул уурхайн хэвийн жигд ажиллагааг хангах нэг нөхцөл болно.

Байгаль цаг уурын гэнэтийн үзэгдлийг урьдчилан мэдэхэд хүндрэлтэй байдаг учраас ил уурхайн ажиллагсдыг дуу цахилгаантай аадар бороо, үерийн ус, хүчтэй салхи, шороон болон цасан шуурганаас хамгаалах нь чухал.

Уурхайн ашиглалтын явцад доорх хэлбэрийн гал түймрийн аюул гарч болзошгүй юм. Үүнд:

- Хээрийн түймэр
- Хайхрамжгүй үйлдлээс болж шатах тослох материалын сав, цахилгаан эх үүсвэр, уурхайн барилга байгууламж шатах гэх мэт
- Болзошгүй галын аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд нийт уурхайчдад тогтмол зааварчилгаа өгч ажиллаж байна
- Гал түймэр, цасны нуралт, шар ус, борооны үерийн аюулаас уурхайг хамгаалахын тулд үерийн усны суваг татаж зарим газарт нь далан

байгуулж хамгаалалт хийсэн

- Уурхайн дотор галын сарай байгуулсан. Галын сарайн бүтцэд төмөр савар /дэгээ/ 3 ш, хувин 2 ш, резинэн цохиур 2 ш, хүрз 3 шир, MFZ/ABC4A маркийн галын хор 2 шир, эсгий 3 м<sup>2</sup> зэрэг багаж хэрэгслийг байрлуулсан.
- Түймэр гарсан тохиолдолд газар авахуулахгүй унтраах анхан шатны арга хэмжээ авах, орон нутгийн байгаль хамгаалагч, холбооны сүлжээг

ашиглан Онцгой байдлын албанд цаг алдалгүй мэдээлэх

Нүүрсний уурхайд буруу үйл ажиллагаа явуулбал аль ч хэсэгт ямар ч аваар, осол, саатал гарч болох үндэстэй. Үйлдвэрлэлийн аваар, осол, саатал, гэмтэл бүр эдийн засагт ихээхэн хохирол учруулдагаас гадна ажиллагсдын аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлдэг. Хүнд аваар ослоос болж ажиллагсад амь насаа алдах, тахир дутуу болох зэрэг эмгэнэлт явдалд ч хүргэдэг. Гадаад орнуудын туршлагаас үзэхэд аливаа уул уурхайн үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны эрсдэлийн байдалд дор дурдсан материалыг судалж, үнэлгээ өгдөг байна.

Үүнд:

- Үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа
- Аваар, осол, саатал гарч болзошгүй шат, дамжлага, тэдгээрийн байршил
- Эдгээр шат дамжлага дахь тоног төхөөрөмж, тэдгээрийн техникийн тодорхойлолт, технологийн горим.
- Аюулгүй ажиллагааны дүрэм, стандарт, журам, заавар
- Аваарь осолд нөлөөлж болох байгаль цаг уурын нөхцөл
- Хортой, шатамхай, тэсрэмтгий бодисын тодорхойлолт, хяналт, хэмжилтийн байдал
- Аюулгүй ажиллагааны системийн удирдлага, зохион байгуулалт, хэтийн бодлого, чиглэл
- Машин механизм, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийн чанар, баталгаа
- Нэгэнт гарсан аваар, осол, саатлын үеийн шуурхай ажлын төлөвлөгөө г.м

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ**

“Хотгор” ХХК нь Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн хэлтсээр батлуулсан 2023 оны уулын ажлын төлөвлөгөө, БОАЖЯ-аар батлуулсан 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани 2023 онд **MV-014442** тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 127750 м<sup>3</sup> хөрс хуулж, 40000 тонн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн ба 2023 оны 10–р сарын 01-ний байдлаар 113428 м<sup>3</sup> хөрс хуулж, 9624.1 тонн нүүрс олборлосон байна.

**MV-001441** тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 112000 м<sup>3</sup> хөрс хуулж, 60 000 тонн нүүрс олборлон борлуулахаар төлөвлөсөн ба 2023 оны 10–р сарын 01-ний байдлаар 127316 м<sup>3</sup> хөрс хуулж, 56329.2 тонн нүүрс олборлон борлуулсан байна. Бүгд 3527827.2 мян. төгрөгийн борлуулалт хийж улсын ба орон нутгийн төсөвт 783610.661 мян. төгрөгийн орлого оруулсан.

### **АШИГЛАЛТЫН СИСТЕМ**

Хотгорын нүүрсний ордын геологийн судлагдсан байдал, нүүрсний давхаргын тогтоц, уурхайн хэтийн төлөв зэргийг үндэслэн, дотоод овоолготой тээвэртэй ашиглалтын системээр ажиллаж байна. Хөрс хуулалт болон нүүрс олборлолтод 0.9 -1 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай КОМАЦУ РС -220, 200 маркийн экскаватор, 1.4- 2 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай 329, 330 маркийн экскаватор, 3 м<sup>3</sup> шанаганы багтаамжтай DOOSAN 520, HYUNDAI 520 маркийн экскаватор, 25 тоннын даацтай HOWO, БЕНЗ маркийн өөрөө буулгагч автомашин ашигласан.

Тус уурхайд чулуулагийг урьдчилан буталж сийрэгжүүлэх зорилгоор Өрөмдлөг-тэсэлгээний ажил хийдэг.

Хөрс хуулалт болон нүүрс олборлолтын ажлыг экскаватор, өөрөө буулгагч автомашины хослолоор гүйцэтгэсэн болно.

Уурхайд ашиглаж буй уулын техникүүд:

№	Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Нэгжийн тоо
1	КОМАЦУ экскаватор	0.9 – 1 м <sup>3</sup>	2
2	CAT 330, 329 экскаватор	1.4 - 2 м <sup>3</sup>	2
3	DOOSAN, HYUNDAI 520 экскаватор	3 м <sup>3</sup>	2
4	Дугуйт ачигч ZL 50 C	3 м <sup>3</sup>	1
5	Дугуйт ачигч XGMA 951	3 м <sup>3</sup>	1
6	Дугуйт ачигч CLG 855	3 м <sup>3</sup>	1
7	Өөрөө буулгагч HOWO автомашин	25 тн	9
8	Өөрөө буулгагч БЕНЗ автомашин	25 тн	1

#### Ажиллах хүч

№	Албан тушаал	Орон тоо
<b>Инженер техникийн ажилтан</b>		
1	Гүйцэтгэх захирал	1
2	Уурхайн дарга	1
3	Механик инженер	1
4	Талбайн мастер	3
5	ХАБЭА-н ажилтан, Байгаль орчны ажилтан	1
6	Шигшүүрийн бригадын ахлагч	1

7	УБ хот дахь төлөөлөгч	1
	<b>Дүн</b>	<b>9</b>
<b>Үйлдвэрийн хэсэг</b>		
1	Экскаваторын операторчин	6
2	Автосамосвалын жолооч	10
3	Өрөмдөгч	4
4	Гагнуурчин	2
5	Тэсэлгээчин	1
6	Ачигчийн оператор	4
7	Засварчин	1
8	Уурхайн хаалгач	1
9	Туслах ажилчин	5
	<b>Дүн</b>	<b>34</b>
<b>Санхүү, аж ахуйн хэсэг</b>		
1	Ня-бо	3
2	ТМ-ын нярав, касс	1
3	Жолооч үйлчилгээний	1
4	ШТМ, сэлбэг хэрэгслийн нярав	2
5	Пүүлэгч	3
6	Захиргааны байрны галч	1
	<b>Дүн</b>	<b>11</b>
	<b>Нийт дүн</b>	<b>54</b>

## **НЭГ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **1. Агаар орчны талаар**

#### **1.1 Нөлөөллийн товч тодорхойлолт**

Уурхайн уулын техникүүд, үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааны үед болон овоолго, уурхайн догол, мөргөцөгүүд, уурхайн дотоод автотээврийн зам, талбай, өрөмдлөг тэсэлгээ зэргээс салхины үйлчлэлээс тоос, шороо хийсч агаар орчныг бохирдуулдаг. 2023 оны 5-р сарын дундаас эхлэн хуурайшилттай үед тоосжилт бууруулах зорилгоор зам, талбайг усаар чийглэж ажилласан болно.

**Шинж чанар:** Хуурайшилт ихтэй ялангуяа хавар, намрын улиралд сул хөрс, шороо салхинд хийсэж ойр орчны агаарыг тоосоор бохирдуулдаг.

**Эх үүсвэр:** Овоолго, олборлолтын талбай, уурхайн дотоод зам талбай

**Бууруулсан арга зам:** Уурхайн дотоод тээврийн зам, ухлагад өртсөн талбайг хуурайшилт ихтэй үед тогтмол усалж тоосыг нь дарж, тоосжилт өндөртэй ажлын байранд ажиллаж байгаа ажилчдыг тусгай хамгаалах хэрэгслээр ханган ажиллаж байна. Жолооч нар уурхай дотор олон салаа зам гаргахгүйгээр зөвхөн анхааруулах

тэмдэг тэмдэглэгээ тавьсан нэг замаар тээвэр хийж байна. Гадны тээврийн хэрэгсэл ч энэ замаар орж гарч байгаа.

Хаврын улиралд хэт их салхитай үе болон их хэмжээний бороо орж уурхайн доторх тээврийн замын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан хөрс хуулах, нүүрс олборлох үйл ажиллагааг 5 удаа зогсоосон байна. Хүнд машин, механизмуудын дотоод шаталтат хөдөлгүүрээс гарах утаа болон хорт хийн хэмжээг мэргэжлийн байгууллагаар оношлуулсан. Стандарт хэмжээнд байгаа.

### 1.2 Нөлөөлөлд өртөх объект:

Нүүрсний уурхай орчмын агаар, уурхайн ажилчид, хөрс, ургамал

### 1.3 Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Төлөвлөсөн зардал, мян. төг	Гүйцэтгэл мян. төг	Хариуцсан албан тушаалтан
1	Цаг агаарын хуурайшилтай үед олборлолтонд өртсөн болон ачиж буулгах талбай, овоолго, уурхайн дотоод тээврийн замыг чийглэх	2023 оны 4, 5, 6, 7, 8, 9 сарууд	4800.0	4620.0	БО асуудал хариуцсан ажилтан
2.	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хуушуувч, амны маск авч өгөх	1 -12 сар	1500.0	1250.0	ХАБЭА-н хариуцан ажилтан
3	Агаар орчны тоосжилтод Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор шинжилгээ хийлгэх	2023 оны 5, 7 сард	444.0	550.0	БО асуудал хариуцсан ажилтан
4	Агаар орчны шинжилгээг БОАЖЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн хамтарсан судалгааны ажлын үеэр 2 дахь удаагаа хийлгэсэн. Шинжилгээний үр дүн стандартын хэмжээнд гарсан.	2023 оны 8-р сард	-	1549.1	Уурхайн дарга БО асуудал хариуцсан ажилтан

## 2. Хөрсний эвдрэл, элэгдэл

### 2.1 Нөлөөллийн товч тодорхойлолт

Уурхайн олборлолтод өртсөн газрын хөрс, геологийн тогтоц эвдрэх, машин механизмын хөдөлгөөний улмаас элэгдэлд орох, тоос болон машин механизмын утаатай хамт хаягдах хорт хий, хүнд металл зэргээр орчны хөрс бохирдоно.

#### Нөлөөлөлд өртөх объект

Уурхайн орчны хөрс, ургамал, хүн, амьтан

### 2.3 Нөхөн сэргээлтийн ажил

№	Ажлын нэр	Хугацаа	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай, га	Зардал, мян. төг	Хариуцсан албан тушаалтан
1	Техникийн нөхөн сэргээлт	5, 6, 7, 8, 9 сарууд	0.79	Үйлдвэрлэлийн зардалд орсон болно	Уурхайн дарга

### 2.4 Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Төлөвлөсөн зардал, мян. төг	Гүйцэтгэл мян. төг	Хариуцсан албан тушаалтан
1	Олон салаа замыг багасгах, зөвхөн 1 замаар зорчуулах зорилгоор 2015 онд <b>Нэг зам</b> төслийн хүрээнд хийгдсэн, замын 2 талд ухаж татсан шуудууг сэргээж, цэвэрлэв. Мөн зарим сэтэлсэн газрыг сэргээж босгов.	2023 оны 5-р сард	1200.0	960.0	Талбайн мастер нар
2	Хөрсний шинжилгээг Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн	2023 оны 7-р сард	372.0	355.8	БО асуудал хариуцсан ажилтан
3	Хөрсний шинжилгээг БОАЖЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн хамтарсан судалгааны ажлын үеэр 2 дахь удаагаа хийлгэсэн. Шинжилгээний үр дүн стандартын хэмжээнд гарсан.	2023 оны 8-р сард	-	1549.1	Уурхайн дарга БО асуудал хариуцсан ажилтан

## Ажиллагсдын нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал

### 3.1 Нөлөөллийн товч тодорхойлолт

Уурхайн тоног төхөөрөмж, техник дээр ажиллагсдын ихэнх нь тоосжилт, дуу чимээ, доргио чичиргээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй ерөнхийдөө хүрээлэн буй орчны физик, химийн бохирдолтой, хөдөлмөрийн хүндэвтэр нөхцөлд ажиллах нөхцөлтэй байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд өртөх, уушигны багтраа, мөгөөрсөн хоолойн өвчтэй болох магадлалтай.

### 3.2 Нөлөөллийн эх үүсвэр

- Орчны болон ажлын байрны тоосжилт
- Машин механизм, тоног төхөөрөмжийн дуу чимээ, доргио чичиргээ, тэнд гарч болох осол
- Ажлын байрны эрүүл ахуйн үзүүлэлт стандартын нормоос бага /температур, дулаан, чийгшил, гэрэлтүүлэг, чимээ шуугиан, доргио чичиргээ/

### 3.3 Нөлөөлөлд өртөх объект. Ажиллагсад

### 3.4 Нөлөөллийг бууруулах, арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний зардал

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Төлөвлөсөн зардал, мян. төг	Гүйцэтгэл, мян. төг	Хариуцсан албан тушаалтан
1	Уурхайн олборлох болон засвар үйлчилгээний цехэд ажилладаг ажилчдыг дуу чимээнээс хамгаалах чихэвчээр хангаж байна	02-р сард	20 хүн 13.0 ₮ = 260 ₮	18 хүн 15.0 ₮ = 270 ₮	ХАБЭА хариуцсан ажилтан

## 4. Усан орчин хамгаалах арга хэмжээ.

### 4.1 Нөлөөллийн товч тодорхойлолт

Олборлолтын явцад уурхайн шүүрүүлээс гарах эрдэсжилт ихтэй хатуу ус, шатах тослох материалын асгаралт, ахуйн бохир усны нэвчилт зэргийн нөлөөгөөр орд орчмын хөрсний болон гүний ус бохирдох зэргээр усны чанар, нөөцөд сөрөг нөлөө учруулж болзошгүй. Нефтийн бүтээгдэхүүн болон шингэн хог хаягдал хаягдаагүй.

**Эх үүсвэр:** Байрны гол, Ямаат гол, гүний худаг

Бууруулсан арга зам: 2023 оны 05-р сарын 06-ны өдөр Байрны болон Шавартын голын гольдрил, гуу жалганд хуримтлагдсан ахуйн хатуу хог хаягдлыг цэвэрлэн цуглуулж, нийт 1 машин буюу 3 орчим тонн хог хаягдлыг Хотгор багийн хог хаягдлын төвлөрсөн цэгт зайлуулав. 2023 оны 7-р сард Ямаатын гол, Байрны голын усыг Увс аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор шинжлүүлсэн. Мөн 8-р сард БОАЖЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний

төвийн хамтарсан судалгааны ажлын үеэр усны шинжилгээг 2 дахь удаагаа хийлгэсэн. Шинжилгээний үр дүн стандартын хэмжээнд гарсан.

#### 4.2 Нөлөөлөлд өртөх объект:

Газар доорхи ус, хүн ам, ургамал

#### 4.3 Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хугацаа	Төлөвлөсөн зардал, мян. төг	Гүйцэтгэл мян. төг	Хариуцсан албан тушаалтан
1	Байрны голын эргийн хатуу хог хаягдлыг цэвэрлэж, зайлуулав	2023 оны 5, 7-р сард	500.0	620.0	БО асуудал хариуцсан ажилтан
2	Усны шинжилгээг Увс аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн	2023 оны 7-р сард	448.0	180.2	БО асуудал хариуцсан ажилтан
3	Усны шинжилгээг БОАЖЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн хамтарсан судалгааны ажлын үеэр 2 дахь удаагаа хийлгэсэн. Шинжилгээний үр дүн стандартын хэмжээнд гарсан.	2023 оны 8-р сард	-	1549.1	Уурхайн дарга БО асуудал хариуцсан ажилтан

### **ХОЁР. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Ашиглалтын явцад олборлолтонд өртөж эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөнд тусган стандарт шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байна.

#### **Техникийн нөхөн сэргээлт**

Техникийн нөхөн сэргээлтийг олборлолтонд өртсөн хоосон талбайд буюу уурхайн малталт хийсэн газруудад хийж байна. Нүүрсний нөөц дууссан нүүрс олборлоход саадгүй болсон талбайд хөрс хуулалтаас гарсан шороо, чулуугаар булж тэгшлэх аргаар уул техникийн нөхөн сэргээлтийг гүйцэтгэв. Энэ нь уурхайн малталтад өртсөн газрыг сул чулуулаг хөрсөөр дүүргэн тэгшилж техникийн нөхөн сэргээлт хийснээр биологийн нөхөн сэргээлт хийх нөхцлийг бүрдүүлнэ.

Нөхөн сэргээгдэж буй газар, түүний хүрээлэн буй орчин нь байгалийн тэнцвэрт байдлаа хадгалсан, унаган төрхөндөө ойртсон, хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг

нөлөөгүй байна. Хөрс хуулалт хийхийн өмнө үржил шимт хөрсийг хуулж тусад нь хадгалж байна. Талбайн үржил шимт хөрсний овоолгын өндөр 2-3 метр болно.

2023 онд MV-014442 талбайн шимт хөрсний овоолгод 1414 м<sup>3</sup> шимт хөрс нэмж ооволсон болно.

1. Хотгорын чулуун нүүрсний ордыг 1963 оноос эхлэн ил уурхайгаар ашиглаж ирсэн. **MV-001441 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ – 39.5 га.**

2023 оны 10-р сарын 01-ний байдлаар MV-001441 талбайн бүгд 25.34 га газар олборлолтонд өртсөн байдаг. 2023 онд хөрс хуулалтаас гарсан шороо, чулуулагаар өмнөх онуудад олборлолтод өртсөн 0.46 га газарт техникийн нөхөн сэргээлт хийв. Нийт 13.65 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн байна.

**2. MV-020853A тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ – 55.62 га.**

2021 онд MV-020853 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд олборлолт явуулсан. 2023 оны 10-р сарын 01-ний байдлаар нийт 11.52 га газар олборлолтод өртсөн байдаг. Олборлолтод өртсөн 11.52 га талбайн 7.26 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. 2023 онд MV-020853 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд олборлолт явуулаагүй.

**3. MV-014442 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээ – 51.25 га.**

2023 онд MV-014442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд олборлолт явуулсан. 2023 оны 10-р сарын 01-ний байдлаар бүгд 8.42 га газар олборлолтод өртсөн байдаг. 2023 онд хөрс хуулалтаас гарсан шороо, чулуулагаар өмнөх онуудад олборлолтод өртсөн 0.33 га газарт техникийн нөхөн сэргээлт хийв. Нийт 1.83 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн байна.

Уурхайн ашиглалтын хугацаанд шимт хөрсний овоолгыг тусд нь хадгалж байна. Жич: 2023 оны байдлаар MV-001441 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 780 м<sup>3</sup>, MV-020853 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 5068 м<sup>3</sup> шимт хөрс, MV-014442 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд 16834 м<sup>3</sup> шимт хөрс байна

### **Биологийн нөхөн сэргээлт**

Биологийн нөхөн сэргээлтийн гол зорилго нь техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг үржил шимт хөрсөөр 0.6 метрийн зузаантайгаар үндсэн хөрсний овоолгын гадаргууг хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлдэнэ. Ингэснээр сөрөг нөлөөлөлд өртсөн газрын хөрс, шороо салхинд хийсч агаар орчныг бохирдуулахаас хамгаалах бөгөөд түүнийг байгалийн унаган төрхөд нь ойртуулах, малын бэлчээрийн зориулалтаар ашиглах боломжийг бүрдүүлнэ.

2023 онд биологийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгдөөгүй болно.

## **ГУРАВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ** **БИЕЛЭЛТ**

Дүйцүүлэн хамгаалах гэдэг маань нөхөн сэргээлт хийж байгаа ч гэсэн уурхай тодорхой хэмжээнд байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэг учраас өөр нэг газарт байгаль орчныг нөхөн сэргээх, ойжуулах арга хэмжээ авна гэсэн үг.

Ил уурхайн олборлолтын явцад эвдэрсэн газрыг тухай бүрт нь нөхөн сэргээх боломж хязгаарлагдмал байдаг учраас түүний ойр орчмын нутаг дэвсгэрт тохиолдох, тухайн нутгийн экосистемд чухал үүрэгтэй, доройтож буй бүлгэмдэл болон популяцыг сэргээх, амьдрах орчныг сайжруулах, хамгаалах зэрэг өөр бусад газруудад экосистемийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлийн ажлыг шат дараалан хэрэгжүүлэх боломжтой.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай. Ландшафтын төвшний төлөвлөлт буюу экологийн бүс нутгийн үнэлгээ нь нөлөөллийг бууруулах эдгээр алхмуудыг зохистой хэрэгжүүлэх үндэс болно.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно. НҮБХХ-ийн санхүүжилтээр БОАЖЯ-наас хэрэгжүүлж буй “Монгол орны баруун бүсэд газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх нь” төсөл хэрэгжиж 2022 онд дууссан байдаг.

2023 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний хүрээнд уурхайн аманд үржлийн мод тарих зорилгоор 6 м x 15 м-ийн харьцаатай 90 м<sup>2</sup> талбайтай хашаа барьж байгуулсан ба түүний дотор 600 гаруй ширхэг бургасны суулгацыг /харандаа/ ургуулж бойжуулахаар тарьсан болно. Суулгацны ургалт 85 %-тай байна.

2023 оны дүйцүүлэн хамгаалах ажилд нийт 2 175 000 төгрөгийн зардал гарсан.

## **ДӨРӨВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тус уурхай 1963 онд анх нээгдэж үйл ажиллагаа явуулж эхэлсний дараа Хотгор тосгон бий болсон. Нүүрст хотгорын уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад ямар нэгэн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гараагүй болно.

## **ТАВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Өнөөгийн байдлаар Бөхмөрөн суманд аялал жуулчлал төдийлөн хөгжөөгүй, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэн явуулдаг жуулчны бааз байхгүй. Гэхдээ тус сум нь унаган төрхөөрөө байгаа онгон дагшин уулс, эртний хүн чулуу, хөшөө дурсгал, хадны бичиг зэргийг агуулсан өвөрмөц тогтоц бүхий байгальтай, үндэстэн, ястны өвөрмөц ахуй, зан үйл зэрэг нь дотоод гадаадын жуулчдыг татах ихээхэн нөөц боломж байна.

Уурхай 1963 оноос өнөөдөр ажиллахдаа эдэлбэр газар болон уурхайн ойр орчимд түүх, соёлын дурсгалын зүйл одоогоор илрээгүй байна.

## **ЗУРГАА. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тус ил уурхайд хөрсний чулуулаг, нүүрсний давхаргыг урьдчилан буталж сийрэгжүүлэх зорилгоор өрөмдлөг, тэсэлгээний ажил хийдэг. Нүүрсний уурхайд ил аргаар олборлолт хийхдээ ANFO маркийн энгийн тэсрэх бодис, МЕРА 300 маркийн бүүстэр /өдөөгч/ ашиглаж байгаа бөгөөд 2023 оны 10-р сарын 01-ны байдлаар 39025 кг ANFO, 2901 шир. МЕРА 300 маркийн бүүстэр /өдөөгч/ ашигласан. Эдгээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө, өрөмдлөг, тэсэлгээний ажлын паспортыг үндэслэн УУХҮЯ-ны Салбарын хяналтын газраас “Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас”-аар олгодог юм. Тэсрэх материалыг Улаанбаатар хотын “МЕРА” ХХК гэрээгээр нийлүүлдэг. МЕРА ХХК-тай ачаа тээвэрлэлтийн гэрээ байгуулж хүргүүлдэг.

Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний үндэсний төвөөр уурхайн гамшгийн эрсдэлийн үнэлгээг 2021 онд шинэчлэн батлуулсан. Тэсрэх материалын агуулах нь газрын гадаргуйгаас хагас далдлагдсан, чулуу ханатай байгууламж. Тэсрэх бодис хадгалах агуулах нь 24 тн, тэсэлгээний хэрэгсэл хадгалах агуулах нь 6 тн багтаамжтай. Гэрээт харуул хамгаалалттай. Агуулахууд нь хяналтын 4 ш теле камертэй.

Тэсрэх материалыг “Хотгор” ХХК-ийн нүүрсний уурхайн химийн хорт бодис болон тэсрэх материалын зарцуулалтанд хяналт тавих журам”-ыг үндэслэн хатуу хяналтын дор олгоно.

Тэсрэх материалыг агуулахаас уурхайн талбайд хүргэхдээ зориулалтын тээврийн хэрэгслээр батлагдсан маршрутын дагуу тээвэрлэж хүргэнэ.

## **ДОЛОО. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Хүнд хэрэггүй бүгдийг хог хаягдал гэнэ. Хүний амьдралын боломж нэмэгдэхийн хирээр хэрэглээ ихсэж хог хаягдлын хэмжээ өсдөг. Хатуу хог хаягдал нь хүрээлэн байгаа орчин /ус, агаар, хөрс/-д болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг. Аливаа хог хаягдлыг ялгах, цуглуулах, зайлуулах, цэвэрлэх, халдваргүйжүүлэх цогц арга хэмжээ нь хүрээлэн буй орчин, хүн амын эрүүл мэндийг хамгаалах ач холбогдолтой. Хотгор тосгонд хогийг ялган ангилах, дахин боловсруулах боломжгүй учраас оршин суугч нар хатуу хог хаягдлыг хогийн саванд цуглуулан овоолж, жилд 2-3 удаа ачиж, Хотгор багийн төвлөрсөн хогийн цэгт зайлуулна.

Нүүрсний уурхайгаас гарах хатуу хог хаягдлыг хогны төмөр саванд цуглуулж, Хотгор багийн хогийн цэгт зайлуулж байна. Уул уурхайн техникээс гарах хатуу хог хаягдал болох машин техникийн сольсон эд анги, аккумулятор, төмрийн хаягдал зэргийг засварын газрын ойролцоо талбайд хурааж байгаад хоёрдогч түүхий эд цуглуулах цэгт нийлүүлнэ.

Ашиглах боломжгүй болсон резин дугуйг тусгай талбайд хурааж байна. Ашигласан тослох материалыг мөн адил төмөр торхонд төрөл төрлөөр нь ангилан цуглуулж байгаад хоёрдогч түүхий эдэд тушаадаг. 1,12-р сард 320 л хаягдал тослох материалыг гэрээний дагуу иргэн Х.Жанарбект нийлүүлсэн.

Техникийн сольсон эд анги, төмрийн хаягдлыг тусгай талбайд хурааж байна.

Уурхайн доторх хог хаягдлыг төмөр саванд цуглуулж, Хотгор багийн хогын цэгт зайлуулсан. Хотгор тосгоны төвлөрсөн хог хаягдлын цэгийн хогийг 2023 оны 5, 10-р саруудад ачигчаар түрж хэлбэржүүлэн овоолсон. 2023 оны хог хаягдлын төлбөр болох 500 000 төгрөгийг Бөхмөрөн сумын ЗДТГ-т төлсөн болно.

2023 оны 04-р сарын 05 –ны өдөр мөн 2023 оны 05-р сарын 05-ны, 2023 оны 07-р сарын 28-ны өдрүүдэд Хотгор багт хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. 2023 оны 05-р сарын 06-ны өдөр Байрны голын гольдрил, гуу жалга, шуудуу зэрэгт хуримтлагдсан ахуйн хатуу хог хаягдлыг цэвэрлэн цуглуулж, нийт 3 гаруй тонн хог хаягдлыг Майти машинаар Хотгор багийн хог хаягдлын төвлөрсөн цэгт зайлуулав. Хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан тухай ажлын тайланг хавсаргав. Ашигласан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав баглаа, боодлыг тусгай бэлтгэсэн зориулалтын талбайд тээвэрлэн хүргэж, шатааж устгасан.

## **НАЙМ. ДОТООД ОВООЛГОД ШАТАЛТ ҮҮССЭН НӨХЦӨЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Сүүлийн жилүүдэд Хотгорын нүүрсний уурхайн техникийн нөхөн сэргээлт хийсэн дотоод овоолгод исэлдэлт явагдаж, стандартын шаардлага хангахгүй хаягдсан чулуулаг нүүрс, шавар, чулуу хэвийн нөхцөлд байхад үе үе утаа гарч заримдаа өөрөө шатах тохиолдолд гараад байна.

Компанийн зүгээс утаа гарч шатах илрэл гарч эхлэнгүүт бүх хүн хүч, машин техникийг дайчлан ажиллаж байгаа ба энэхүү үйл ажиллагаанд жилд 200 000 000 ₮ дээш

хэмжээний үргүй зардал гарч санхүүгийн хүндрэл учирахаас гадна орчны агаарыг зохих хэмжээгээр бохирдуулах эрсдэлтэй.

Утаа уугиж шатаж байгаа хэсгийг ачиж аюулгүй талбайд зөөвөрлөх эсвэл элс хайрга бүхий хөрсөөр дарж унтраах зэрэг арга хэрэглэж байсан.

2021 оны 12-р сарын эхээр Монголын Уул уурхайн мэргэжлийн холбоодын зөвлөлд шинжээчин дүгнэлт гаргуулахаар хүсэлт тавьж, 2021 оны 12-р сарын 30-ны өдөр “Сэцэн Болор Өргөө” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан.

Монгол улсын зөвлөх инженер Ж.Бат тэргүүтэй мэргэжлийн хүмүүс уурхайд ирж ажиллаж, уурхайн галыг унтраах ажлын тайлан боловсруулж, утаа уугиж шатаж буй дотоод овоолго, асч буй галыг 4 - 8 %-ийн шохойн уусмалаар унтраах аргыг зөвлөмж болгосон юм.

Уурхайн дотоод овоолгод шатлага явагдаж, утаа уугиж шатах үед “Мөнхийн-Оргил” ХХК-ийн боловсруулсан “Нүүрст хотгорын уурхайд гарсан галыг унтраах ажлын тайлан”-гийн зөвлөмжийн дагуу ажиллана. ОБЕГазрын дэргэдэх Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн 2022 оны 03-р сарын 21-ний өдрийн санал дүгнэлтийг хэрэгжүүлэн ажиллах болно.

Мөн дотоод овоогод шатлага гарсан зарим тохиолдолд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Шатаж буй голомтыг ачиж аюулгүй талбайд зөөвөрлөх.
2. Шатлага явагдаж байгаа талбайг элс хайрга бүхий хөрсөөр зузаан дарж вакуум орчин үүсгэж шатлагын голомтыг зогсоох.
3. Дотоод овоолгод утаа үүсэх үед нь экскаватор ашиглан бусад хэсгээс тасалснаар /таслан унтраах/ цаашид утаа уугиж тархан дэлгэрэх нөхцөлийг хязгаарлана.

Шатлага явагдаж, утаа уугиж байгаа голомтыг зөөвөрлөх, элсээр дарах, таслан унтраах ажилд экскаватор, өөрөө буулгагч автомашин, авто ачигч зэрэг уул уурхайн техникийг ашиглана. Шатаж байгаа голомтыг ачиж зөөвөрлөхөд ил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахиж, голомтод ажиллаж байгаа ажиллагсдад хамгаалах хэрэгсэл олгоно.

Талбайд ажиллаж байгаа ажиллагсдын аюулгүй байдлыг хангах, угаартахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. Голомтод ажиллах ажилчдад халуун хоол, хор саармагжуулах сүү, хамгаалах хэрэгслүүдийг тухай бүр олгоно.

Уурхайн өөрөө шаталтын голомтыг өдөр бүр шалгаж, шалгалтын мөрөөр тухай бүр арга хэмжээ авч ажиллах болно.

**Дотоод овоолго** гэдэг нь олборлолтод өртсөн, нүүрсний нөөц нь дууссан хоосон талбайг хөрс хуулалтаас гарсан хөрс, чулуулаг, стандартын шаардлага хангахгүй исэлдсэн, шавар чулуу холилдсон хаягдал нүүрс зэргээр дүүргэлт хийж, булж тэгшлэх аргаар техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай.

Хөрс хуулах, нүүрс олборлон борлуулах үед үүсэх хог хаягдлын гол эх үүсвэрүүд:

Хаягдлын ангилал	Анхдагч эх үүсвэр	Хог хаягдлын төрөл	Хог хаягдлыг цуглуулж, зайлуулсан нь
Ахуйн хог хаягдал	Гал тогоо, оршин суух байр, наряд, амралтын өрөө	Цаас, баглаа боодол, хүнсний хаягдлууд, шил, сав, лааз, хуванцар, гялгар уут, зуухнаас гарах үнс	5 м * 3 м хэмжээтэй хогны төмөр саванд цуглуулж, тосгоны хогийн цэгэнд 2 удаагийн ачилтаар зайлуулсан
Үйлдвэрийн техникийн хог хаягдал	Техникийн засварын цех, талбай, автогараж	Арчих даавуун материал, техникийн маслын, агаарын, түлшний шүүрнүүд, аккумулятор, резин дугуй, ашиглах боломжгүй болсон сэлбэг хэрэгслүүд гэх мэт	Техникийн шүүрнүүдийг хогийн цэгэнд, аккумулятор, машин техникийн сольсон эд анги, төмрийн хаягдлыг талбайд хурааж байгаад хоёрдогч түүхий эд худалдан авдаг иргэдэд тушаасан. Хуучин дугуй талбайд хураалттай байгаа. Бусад хог хаягдлыг хогны төмөр саванд цуглуулж, тосгоны хогийн цэгэнд зайлуулсан байдаг
Ашигласан тослох материал	Техникийн засварын цех, талбай	Хөдөлгүүрийн тос, хүч дамжуулах хэсгийн ТАП, гидрийн шингэн, товуд	Төрөл төрлөөр нь төмөр торхонд ангилан цуглуулж, хоёрдогч түүхий эдэд тушаасан
Бохир ус	Гал тогоо, оршин суух байр, халуун ус	Саарал ус	Тусгай цооногт нийлүүлж байна.

### **ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСЭН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Байгаль орчныг хамгаалах, хяналт тавих, нөхөн сэргээлт хийх ажлыг уурхайн дарга, ерөнхий инженер, байгаль орчны асуудал хариуцсан ажилтан нар хариуцсан гүйцэтгэж байна. 2023 онд 0.79 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг улирал бүр гаргаж, Бөхмөрөн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч-д хүргүүлж байв. Нөхөн сэргээлт хийсэн талбайг орон нутгийн захиргаанд хүлээлгэн өгнө.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг Бөхмөрөн сум, багийн удирдлага, Хотгор багийн Засаг дарга болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулсан. Санхүүжилтийг компани хариуцав. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажилд компанийн нийт ажиллагсад оролцов. Төлөвлөгөөний гүйцэтгэлд компанийн захирал хатуу хяналт тавьж ажилласан.

**БОМТөлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.**

**Үүнд:**

№	Ажлын төрөл	Хийж гүйцэтгэсэн хугацаа	Хариуцсан албан тушаалтан	Хяналт тавьсан албан тушаалтан
1	Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай 2023 оны Ус ашиглах гэрээ байгуулсан	2023 он 01-р сар	Гүйцэтгэх захирал З.Кадирхан	
2	Хуурайшилттай үед овоолго, талбай, уурхайн дотоод тээврийн замыг чийглэж ажилласан. Мод, зүлэг усалсан	5 - 9 сарын хооронд	БО хариуцсан ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
3	Ажиллагсдыг тоосноос хамгаалах хушуувч, амны хаалт, дуу чимээ ихтэй газарт ажилладаг ажиллагсдыг чихэвчээр хангасан.	Жилийн турш	ХАБЭА ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
4	Увс аймгийн УЦУОШТөв-тэй байгуулсан гэрээний дагуу агаар, хөрс, усны шинжилгээг хийлгэсэн. БОАЖЯ-аас хөрс, агаар, усны шинжилгээг давхар хийсэн болно.	7, 8, 10-р сар	БО хариуцсан ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
5	2023 оны Дүйцүүлэн хамгаалах болон Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 400 ш бургас мод, 600 ш бургас модны суулгац /харандаа/ тарьж, арчлан хамгаалж ургуулсан.	4- 9-р сард	БО хариуцсан ажилтан Т.Жумахан	Гүйцэтгэх захирал З.Кадирхан
7	Техникийн нөхөн сэргээлтийн ажил хийсэн. 0.79 га	5 – 9 сард	Байгаль орчны ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
8	Хотгор багийн хэмжээнд хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, цуглуулсан хатуу хог хаягдлыг Хотгор багийн төвлөрсөн хогын цэгт зайлуулсан.Багийн төвлөрсөн хогийн цэгийн хогийг 2 удаа ачигчаар түрж овоолж хэлбэржүүлсэн	2023 оны 5, 10-р саруудад	БО хариуцсан ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга М.Аманкелди
9	Техникийн сольсон эд анги, төмрийн хаягдлыг цуглуулж, тусгай талбайд хураасан	байнга	Уурхайн дарга М.Аманкелди Механик инженер Х.Еркетай	Гүйцэтгэх захирал З.Кадирхан
10	Байрны голын сайр дагуу хогийг цэвэрлэж, Хотгор багийн хогийн цэгт зайлуулав. Борооны ус, үерийн хамгаалалтын шуудууг сэргээж цэвэрлэв. Анхааруулах, сануулах тэмдэгүүдийг шинэчилж тавив.	5, 8 сард	БО хариуцсан ажилтан Т.Жумахан	Уурхайн дарга

## **АРАВ. “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖИЛ**

Мод тарих ажлын хүрээнд 2023 оны 04-р сарын 05-ны өдрөөс 04-р сарын 25-ны хүртэл  $48 \text{ м} \times 22 \text{ м} = 1056 \text{ м}^2$  талбайн хэмжээтэй, 1.5 м өндөртэй төмөр торон хашааг автопүүний талбайн дэргэд шинээр барьж байгуулав. Хашааны шонгийн нүх ухах, шонгийн мод суулгах, тор татах, хашааны дээд, доод талыг төмөр утсаар татах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв. Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхэд 4 хүн тогтмол ажилласан.

Уурхайн ам буюу авто пүүний талбайн дэргэд “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд 2023 оны 05-р сарын 07-ний амралтын өдрийг мод тарих өдөр болгон, нийт ажилчдыг оролцуулж 400 ширхэг мод тарих нүх ухаж бэлтгэв. Үүнд нийт 31 хүн оролцов.

Уурхайн аманд үржлийн мод тарих зорилгоор 6 м х 15 метрийн харьцаатай  $90 \text{ м}^2$  хашаа барьж байгуулсан ба түүний дотор 600 ширхэг бургасны суулгацыг /харандаа/ ургуулж бойжуулахаар тарьсан болно. Энэхүү ажлуудыг 2023 оны 05-р сарын 07-ны өдрөөс эхлэн 05-р сарын 15-ний хүртэл хугацаанд хийж гүйцэтгэсэн ба 4 хүн тогтмол ажилласан

Тарьсан модыг услах зорилгоор аж ахуйн хашаан доторх гүний худагнаас мод тарьсан талбай хүртэл шуудуу ухаж, ус гүйх шланга булж ажилласан болно. Уг ажлыг 05-р сарын 07-ны өдрөөс эхлэн 05-р сарын 11-ний хүртэл хийж гүйцэтгэв.

Мод тарих ажлыг 05-р сарын 07-ноос 05-р сарын 15-ны өдөр хооронд хийж гүйцэтгэсэн. 2022 онд 600 ширхэг бургас модны суулгацыг /харандаа/ ургуулж бойжуулахаар тарьсан байдаг. Энэхүү суулгацнаас /1 настай/ 400 ширхэгийг авч тарьж, усалгаа хийж, мод тариалалтын ажлыг бүрэн хийж дуусгав. Үүнд 4 хүн тогтмол ажилласан болно. Эдгээр хийж гүйцэтгэсэн бүх ажлуудыг зургаар баталгаажуулж хавсаргав. Мод болон суулгацыг /харандаа/ усалж, арчлан хамгаалж, ургуулах ажлыг 2 ажилтанд хариуцуулан ажиллаж байна.

2023 оны тэрбум модны ажилд нийт 5 070 140 төгрөгийн зардал гарсан.

**АРВАН НЭГ. ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Зохион байгуулах газар
Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2023.05	Аймгийн БОАЖГазар
Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Хэрэгжилтийг хянуулах	БОМТ	2023.07	Аймгийн БОАЖГазар
Орон нутагт /тухайн төсөл хэрэгжих бүс нутагт байгаа хүмүүс/ тайлагнах	Тайлангийн танилцуулга	БОМТ	2023.10	Уурхай
Орон нутгийн засаг захиргаа	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2023.10	Уурхай
Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар	Хэрэгжилтийг тайлагнах	БОМТ	2023.11	Аймгийн БОАЖГазар

**АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ**

Хяналт шинжилгээний дээж	Дээж авах цэгийн тоо	Дээж авах цэгийн байршил	Давтамж		Төлөвлөсөн төсөв, ₮	Гүйцэтгэл ₮	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
1	Хөрс: Аймгийн УЦУОШТөв	3	Хөрс хуулалт, олборлолт явагдаж буй талбай	Жилд 1 удаа	1 удаа	372 000	355 800
	Хөрс: БОАЖЯ		Эдэлбэр газрын талбай	-	1 удаа	-	1 549 166
2	Ус: Аймгийн УЦУОШТөв	2	Ямаатын гол, Байрны гол	Жилд 2 удаа	2 удаа	448 000	180 200
	Ус: БОАЖЯ		Байрны гол Ямаатын гол	-	1 удаа	-	1 549 166
3	Агаар: Аймгийн УЦУОШТөв	3	Хөрс, нүүрсний ажил явагдаж буй талбай, тосгон	Жилд 2 удаа	2 удаа	444 000	550 000
	Агаар: БОАЖЯ		Уурхай дотор, тосгон	-	1 удаа	-	1 599 166
<b>ДҮН</b>						<b>1 264 000</b>	<b>5 733 498</b>

**“ХОТГОР” ХХК-ИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙД 2023 ОНД АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЯВУУЛАХАД БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ БОЛОН “ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ  
ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН  
ЗАРДЛЫН ТОВЧОО**

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Төлөвлөсөн зардал, ₮	Гүйцэтгэл ₮	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	13 596 000	20 059 370	- Цаг агаарын хуурайшилтай үед олборлолтонд өртсөн болон ачиж буулгах талбай, овоолго, уурхайн дотоод тээврийн замыг чийглэх – 4 620 000 ₮ - Байрны голын сайр дагуу болон Хотгор багийн төвийн хог хаягдал, борооны ус, үерийн хамгаалалтын шуудууг цэвэрлэсэн - 1 120 000 ₮ - Амьтдын амьдрах, үржих чулуун хоргог - 180 000 ₮ - Олон салаа замыг багсгах зорилгоор 2015 онд Нэг зам төслийн хүрээнд хийгдсэн замын 2 талд ухаж татсан шуудууг цэвэрлэв – 960 000 ₮ - Тоосжилт үүсэх газарт ажиллаж байгаа ажиллагсдыг тоосноос хамгаалах хуушуувч, амны маскаар хангах ажилд - 1 250 000 ₮ - Анхааруулах, сануулах тэмдэг, тэмдэглэгээ, мэдээллийн самбар 13 ш- 303 500 ₮ - “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн аманд тарьж ургуулсан 400 ш 1 настай бургас тарьж ургуулсан, арчлан хамгаалсан зардал – 5 070 140 ₮ - Хотгор тосгоны оршин суугч айл өрхийн гудамжинд эзэнгүй хаясан хог хаягдлыг ачиж хогийн цэгт зайлуулсан -230 000 ₮, - Шимт хөрсний зардал – 1 825 830 ₮ - Уурхайн дотоод овоолгод гарсан шатлага, галыг унтраахад зарцуулсан шохой, ус - 3 750 000 ₮ - Насос, шланг, багаж хэрэгслийн үнэ – 750 000 ₮
2	Нөхөн сэргээх арга хэмжээний төсөв	-		Хөрс хуулалтаас гарсан шороо, чулуулагаар дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийсэн. Төсөв нь 2023 оны уулын ажлын төлөвлөгөөний үйлдвэрийн зардал дотор орсон.
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	-	2 175 000	2023 онд Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд уурхайн аманд 6 м х 15 м хэмжээтэй талбайд төмөр торон хашаа татаж, 600 ширхэг бургас модны суулгац /харандаа/ суулгаж, усалж, арчлан хамгаалж, ургуулав.
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төсөв	-	-	Хамааралгүй
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төсөв	250 000	-	-
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн зардал	450 000	600 000	Ашигласан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн сав, баглаа боодлыг тусгай талбайд шатааж устгав
7	Хог, хаягдлын арга хэмжээний төсөв	1 236 000	1 080 000	- Хотгор багийн төвлөрсөн хогийн цэгийн задгай асгасан хогийг Дугуйт ачигчаар 5, 10-р саруудад 2 удаа түрж овоолж хэлбэржүүлсэн. - Уурхайн хатуу хог хаягдлыг ачиж зайлуулав.

8	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төсөв	500 000	-	Зардал нь 2023 оны уулын ажлын төлөвлөгөөний захиргааны зардалд орсон.
9	Олон нийтэд тайлагнах зардал	-	-	Зардал нь 2023 оны Уулын ажлын төлөвлөгөөний захиргааны зардлын дотор орсон
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн арга хэмжээний төсөв	1 264 000	1 086 000	Увс аймгийн УЦУОШТөв-тэй байгуулсан гэрээний дагуу агаарын шинжилгээг 2 удаа, ус, хөрсний шинжилгээг тус бүр 1 удаа хийлгэхэд холбогдон гарсан зардал
		-	4 647 500	2023 оны 08-р сард БОАЖЯ болон Байгаль орчны судалгаа, шинжилгээний төвийн хамтарсан судалгааны ажлын үеэр авсан хөрс, ус, агаар орчны шинжилгээний төлбөр
	<b>Д Ү Н</b>	<b>17 296 000</b>	<b>29 898 550</b>	

**“ХОТГОР” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭХ ХУУДАС**

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Биелэлтийн хувь	Тайлбар, үндэслэл
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт		
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт		
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт		
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт		
9	Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт		
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл		

“ХОТГОР” ХХК-ИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙГ ХҮЛЭЭЖ АВАХ, ДҮГНЭХ ХУУДАС

Огноо: .....

Дугаар: .....

Байршил:.....

Ажлын хэсгийн дарга:

.....  
.....

Гишүүд:

- Увс аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч .....
- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөөлөл .....
- Сав газрын захиргааны төлөөлөл .....
- Бөхмөрөн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч .....
- Бөхмөрөн сумын байгаль хамгаалагч .....
- Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл .....
- Бөхмөрөн сумын газрын даамал .....

Хүлээн зөвшөөрсөн:

“Хотгор” ХХК-ийн байгаль орчны ажилтан

Т.Жумахан







